

ДеФакто **ТОЙМ**

➤ ХӨГЖЛИЙН БАНК  
БОЛОН ЭРДЭНЭТИЙН  
ШАЛГАЛТЫН ДҮН

➤ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ХАРИУ ЦОХИЛТ

➤ ЕВРАЗИЙН ХЭВЛЭЛ  
МЭДЭЭЛЛИЙН ФОРУМ  
2019

XII НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

*Д.Жаргалсайхан*  
Эдийн засагч, нийтлэлч

# Евразийн алсын ИНТЕГРАЦИ

II НҮҮРТ



**САЙН ЗАСАГЛАЛ**

**О.Мөнхбат**

Доктор, МУИС-ийн Профессор

# ХУАГАЙДАГДСАН

СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ БҮЮУ **МОНГОЛЫН СОНГУУЛЬ**

V НҮҮРТ



**ЭРҮҮЛ МЭНД**

**Б.Цэцэгсайхан**

Хавдрын үндэсний зөвлөл ТББ-ын  
гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор

ТАМХИ БОЛ ХЭРЭГЛЭГЧДИЙНХЭЭ ТАЛААС ИЛҮҮГ НЬ  
**ҮХҮҮЛДЭГ** БҮТЭЭГДЭХҮҮН

IX НҮҮРТ

**WEEKLY**

# The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Баасан, 2019.05.31, №7 (99)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,  
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.defacto.mn



Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,  
<http://jargaldefacto.com/category/23>

# Евразийн алсын ИНТЕГРАЦИ

**2019** оны 5-р сарын 22-24-ний өдрүүдэд Казахстаны Алма-Аты хотноо “Евразийн хэвлэл мэдээллийн форум” олон улсын чуулган хуралдав. 16 дахь жилдээ болсон энэ үйл ажиллагаанд Ази Европын 40-өөд орны 600-аад төлөөлөгчид оролцож Итгэлийн хямрал буюу олон улсын хүчний тэнцвэр, Хиймэл оюун ухааны эрин үе буюу хүн төрөлхтний сэргэн мандалт, Де-глобалчлал буюу хөгжлийн шинэ загварыг хайж буй дэлхий зэрэг сэдвээр ярилцав.

Мөн Мобайл, байгаль орчны, гэрэл зургийн

сэтгүүл зүй зэрэг сэдвээр сургалт явуулав. Энэ үйл ажиллагаанд Д.Трампын сонгуулийн менежер Стив Баннон, Их Британийн парламентын гишүүн асан, сэтгүүлч Жорж Галавей, Европын Холбооны комиссар Бенита Ферреро-Валднер, Украйны сэтгүүлч Дмитри Гордон, Оросын сэтгүүлч Михайл Шевченко зэрэг нэр цуутай олон хүмүүс үг хэлэв. Еврази, ялангуяа Казахстаны улс төр, эдийн засаг, иргэний нийгмийн байдал, ямар өөрчлөлт явагдаж буйг ажиглах, төрийн болон хэвлэл мэдээллийн онцлог хүмүүсийг сонсож, уулзаж ярилцах сайхан боломж тохиов.

## КАЗАХСТАНЫ ХҮСЭЛ ТЭМҮҮЛЭЛ

Энд нэг хүний засаглалын эрин шувтарч байна. 50-аад хоногийн өмнө 30 жил төрийн эрх барьсан, 80 нас шүргэж яваа Н.Назарбаев ерөнхийлөгчийнхөө эрх мэдлийн хагасыг 65 настай Касым Жомарт Токаевт шилжүүлжээ. К.Токаев тангараг өргөх ёслол дээрээ нийслэл Астанаг Нурсалтан гэж нэрлэх санал гаргав. 6-р сарын 9-нд болох Ерөнхийлөгчийн ээлжит бус сонгуульд 7 хүн өрсөлдөнө гэнэ. Энэ сонгууль нь, Орост найман хүн өрсөлдөөд нэг нь 77 хувийн санал авсантай тун төсөөтэй болох юм.

Казахстан сүүлийн 20-оод жилд Евразийн орон зайн гол төв нь болох төрийн бодлого явуулж ирлээ. Сүүлийн 12 жил тутам “Астанагийн эдийн засгийн форум” зохион байгуулав. 74 орны улс төр, бизнес, судлаачдын төлөөлөл оролцсон 2019 оны форумыг “Деловой Казахстан” сонин

нь “Азийн Давос” боллоо гэжээ. Өөр нэг жишээ нь долоо хоногийн дараа Алма Аты-д болсон дээрх Медиа форум юм. Эдгээр томоохон үйл ажиллагаанд олон улсын байгууллагууд, АНУ, Европын Холбоо, Хятад, Орос зэрэг улс орноос улс төр, бизнесийн томчууд ирж оролцдог уламжлал тогтож байна.

*Евразийн хэвлэл мэдээллийн форум дээр “Хүний эрхийг зөрчдөг, сэтгүүлчдийг үзэл бодлоо илэрхийлсний төлөө шоронд хорьдог, оройн цагаар интернетийн хурдыг сааруулдаг, үг хэлэх эрх чөлөөгүй энэ улсад яагаад энэ чухал хурлыг зохион байгуулж байгаа юм бэ? гэсэн асуулт оролцогчдоос тавихад “Тийм учраас байдлыг өөрчлөх гэж энд хуралдаж байгаа” гэж хариулав.*

- ▶ Казахстанд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь төрийн, эсвэл цөөхөн олигархын эрх мэдэлд байдаг ажээ. Төр засгийн бодлогыг шүүмжилвэл дарамталж, эсвэл хаадаг учраас хэвлэлийн эрх чөлөө бага. “Хил хязгааргүй сэтгүүлчид” байгууллагын 2019 оны дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр Казахстан 180 орноос 158-р байранд оров.

*Казахстаны эдийн засгийн суурь, төр засгийн өндөр зардлыг нь хааж байгаа ганц аврал нь газрын тос. Газрын тосныхоо ачаар сайн дэд бүтэц барьж байгуулсаар ирсэн. 2018 онд экспортын 70 хувийг эзэлсэн газрын тосоороо 42.7 тэрбум доллар олжээ.*

Энэ улс хүн төрөлхтний амжилт бүтээлээс сургамж авч чадаж байна. Нийслэлээ олон улсын 52 шилдэг компанийн саналыг авч, Японы архитектор К.Куракава, Английн Н.Фостер нарын төслийг сонгон шалгаруулж орчим үеийн өвөрмөц шийдлээр барьсан.

## ЕВРАЗИЙН ИНТЕГРАЦИЙН ЗАМД

Евразид европ, ази тивийн бүх улсыг хамруулдаг боловч Дундад Азийн орнууд Казахстан, Түркменистан, Узбекистан, Тажикистан, Кыргызстан нарын хувьд орших орон зайг нь нэгтгэсэн, хамтран ажиллах тухайгаа ярилцах талбар нь болоод байна.

ДУНДАД АЗИ						
Улс	Хүн ам (Сая/2019 он)	Газар нутаг (км2/2018 он)	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (Доллар/2017он)	Хэвлэлийн эрх чөлөө (2019 он)	Ерөнхийлөгчийн ноос одоог хүртэл	
	<a href="http://worldometers.info">worldometers.info</a>	<a href="http://data.worldbank.org">data.worldbank.org</a>	<a href="http://tradingeconomics.com">tradingeconomics.com</a>	<a href="http://rsf.org">rsf.org</a>	<a href="http://worldatlas.com">worldatlas.com</a>	
1 Узбекистан	32.8	425,400	2031	165 / 180	2	
2 Казахстан	18.6	2,699,700	10857	158 / 180	1	
3 Тажикистан	9.3	138,790	1015	149 / 180	3	
4 Кыргызстан	6.2	191,800	1070	98 / 180	5	
5 Түркменистан	5.9	469,930	7317	178 / 180	2	
ТӨВ АЗИ						
1 Монгол	3.2	1,553,560	4071	71 / 180	5	

Эдгээр пост-совет улсууд түүх, соёл, шашин, төрийн байгууламж, Орос, Хятадаас эдүгээ улам бүр хамааралтай болж байгаа зэрэг олон талаараа адил төстэй, бараг л “нэг гарын таван хуруу” ч гэж болохоор ажээ. Эрт дээр цагт эдгээр улсуудын газар нутгаар дайрч байсан торгоны замууд Монголын эзэнт гүрэн худалдаачдын аюулгүй байдлыг батлан хамгаалж байсан тул ази европын соёл иргэншил уулзах гүүр болсон гэж Jack Weatherford “Genghis Khan and the Making of the Modern World” номондоо бичжээ.

Эдгээр станы таван орон саяхан болтол хил хязгаараа нарийвчлан тохиролцож чадахгүй, маргалдан зөрчилдөж, зарим нь хилийн

зурвасаараа дэлбэрэх бөмбөг булж байсан гэж Евразийн интеграцийн тухай дугуй ширээний уулзалт дээр нэгэн оролцогч хэллээ.

*Улс орнуудын интеграци бол худалдаа, үйлдвэрлэл, нийлүүлэлт, санхүү, хөдөлмөрийн нэгдсэн зах зээлтэй болохыг хэлдэг. Одоогийн байдлаар станы таван орон энэ тухай дөнгөж ярилцаж эхэлж байна. Хүн ам нь нийлээд 70-аад саяд хүрч, Германтай дүйцэхүйц том зах зээл болжээ. Мэдээлэл, харилцаа холбооны хувьсгалын эрин үед энэ зах зээл дээр хамтран ажиллах боломж улам олноор байна.*

▶ Аливаа хамтын ажиллагаа эхлэхээс өмнө талууд харилцан ярилцах, бүрэн ойлголцох, итгэлцэл бий болох ёстой. Энэ таван орны хувьд бол харилцан ярилцах үйлдэл нь төр засгийн хэмжээнд дөнгөж өрнөж байна. Нэр томъёоны ойлголтоо нэг болгох, алсын хараагаа хуваалцаж, нэгдсэн зорилготой болтол удирдагчдаас нь ихээхэн тэвчээр, уужуу сэтгэл шаардах бололтой.

Энэ бүс нутаг нь дэлхийн гол үйл явдлаас

алслагдсан, Орос Хятадаас бүрэн хамааралтай учир Монголтой төсөөтэй. Армян, Беларус, Орос, Казахстан, Кыргыз улсуудыг нэгтгэсэн Евразийн эдийн засгийн холбоонд хоёр нь нэгдсэнийг эс тооцвол, тэдний хамтарсан өөр холбоо алга байна. Тэгээд ч энэ холбоонд орсон жижиг орны үйлдвэрлэгчид том орны гаалийн татваргүй бараанд цохигдон дампуурч байгаа гэж бид замдаа саатсан Бишкекд ярьж байлаа.



Ямар ч гэсэн харилцан ярилцахыг (communication) төр засгийн түвшинд эхлүүлж байгаа нь сайшаалтай. Европын орнууд II дайны дараа нүүрс, гангийн үйлдвэрлэлээ зохицуулах тухай ярилцаж эхэлснээр өнөөгийн Европын холбооны суурийг тавьсан. Түүнтэй адил евразийн таван орон жишээлбэл усыг тойруулан ийм ярилцлага өрнүүлэх боломжтой. Тажикистан нь бусад дөрвөн улсынхаа ундны усны хэрэгцээний 70 хувийг хангадаг ч, саяхан болтол маргаан гарсаар байлаа.

*Улс орны хооронд ойлголцохын тулд иргэд, иргэний нийгэм нь харилцан ярилцах шаардлагатай. Зөвхөн энгийн иргэд, жижиг дунд бизнесийн харилцан ойлголцол нь эдийн засгийн хамтын ажиллагааг “чирж” явдаг. Одоо бол “ачаа нь мориныхоо урд” байна.*

Иргэд харилцан ярилцаж, ойлголцохын тулд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх ёстой. Гэвч тийм боломж Кыргызстанаас бусад орны иргэдэд нь хязгаарлагдмал байна. Хязгаарласан хэмжээгээр нь иргэний нийгэм буюу мэдээлэлтэй иргэдийн дуу хоолой сонсогдохгүй байна гэсэн үг. Хятадын зам ба бүс санаачилга энэ бүс нутагт эрчимтэй хэрэгжиж, зарим улс нь “залгиж чадахгүй” том төслүүд “үмхэж” байгаа нь улс төр, эдийн засгийн эрсдэл дагуулж байна.

Монголын хувьд дундад азийн улсуудтай харьцуулахад хүний аюулгүй байдал, эрх, эрх чөлөө, хөрөнгийг хамгаалах талаар томоохон амжилтад хүрчээ. Хэдийгээр авлигатай ч, Монголын иргэд ганц нэг хүнээс хамаардаггүй, төр засаг нь иргэдийн дуу хоолойг сонсохгүйгээр ямар ч шийдвэр гаргах боломжгүй юм.



НИЙТЛЭЛ

О.МӨНХБАТ

Доктор, МУИС-ийн Профессор

# ХУАГАЙЛАГДСАН

СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ БУЮУ **МОНГОЛЫН СОНГУУЛЬ**

2017 оны ерөнхийлөгчийн ээлжит [сонгуулийн](#) хоёр дахь санал хураалтын дүнгээр нийт санал өгсөн 1 сая 207 мянга 787 иргэний 99 мянга 494 иргэн буюу 8.23 хувь нь санал огт тэмдэглээгүй “цагаан” хуудас тоолуулсан онцлог үйл явдал гарав. Тухайн үед үүнийг анхан шатны сонгуульд бүдэрсэн нэг нэр дэвшигч, нэг улс төрийн намын “өшөө хорсол” мэтээр тайлбарлаад өнгөрсөн авч чухамдаа Монгол дахь сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт хямралд идэгдсэний ноцтой дохио энэ байлаа.

Монгол улсын Үндсэн хуулийн 16.9-д, Сонгуулийн тухай [хуулийн](#) 2.11-д заасан сонгох сонгогдох эрхээ бид УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн хурал зэрэг 3 сонгуульд 4 жилдээ нэг удаа эдэлдэг.

- ♦ Харин бодит байдал дээр энэ эрх маань ямаршуухан байдалтай байна вэ?

- ♦ Бид хүссэн хүнээ эсвэл өөрийгөө нэр дэвшүүлж, түүнийхээ төлөө саналаа өгөх эрхтэй байна уу үгүй юу?
- ♦ “Дургүй бандийг дарж байж сахил хүртээв” гэдгийн адил хэн нэгний урьдчилан найруулсан сонгууль жүжигт оролцож, “лам олдохгүй бол буцахдаа таныг зална” гэсэн үлгэрээр хуудсанд бичсэн нэгнийг дугуйлсан болоод өнгөрч байна уу?
- ♦ Сонгогдсон гишүүн нь элдвээр аяглаж, эрүүл галзуу нь мэдэгдэхгүй аашилж, идэж уухыг үзүүлээд өгөхөөр “үгүй энэ нөхөр чинь хаанаас яагаад гараад ирэв ээ” гэж нэгнээсээ асуун гайхах сонгогч. Энэ мэт олон асуулт байна аа.

Чухамдаа “жирийн үхэх заяатан” бидний сонгох, сонгогдох эрхийг хулгайлах нүдэнд үл үзэгдэж, чихэнд үл сонсдох их ажил далд өрнөдөг бөгөөд түүний схемийг нэг харъя.

## АСУУЛТ 1. УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ТОЙРОГ ХУВААХ ТОХИРОЛЦООН ГЭЖ ЮУ БОЛОХ

1992 онд УИХ-ын анхны сонгуульдаа санал өгөх эрхтэй иргэдийн 95.6 хувь оролцож, Монгол даяараа итгэн найдаж асан тэр үед энэ ойлголт байсангүй. Харин дараа дараагийн УИХ-ын сонгуулийн үед намууд хүчирхэгжиж, эрх мэдлийн амт авч, “түрийвчээрээ” нэгдэх болсон үеэс УИХ-ын сонгууль улмаар иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд тойрог хуваах гэсэн энэ ойлголт гарч ирэв. Тойрог жижгэрч 76 болсон нь үүнд мөн ташуур өгчээ.

Улс төрийн намуудын удирдлагын түвшинд сонгуулийн тодорхой тойрогт нэг нам нь найдвартай гаргах гэсэн хүнээ дэвшүүлэх бусад нь дүр эсгэсэн өрсөлдөөн харуулах үүднээс нэр дэвшүүлэхгүй хаях эс бөгөөс сул, олонд танигдаагүй хүнээ дэвшүүлсэн болох тохироог ийнхүү нэрлэх аж.

Энэ тохиролцоо бол ихэвчлэн төр барилцдаг намын удирдлагад байгаа нөхдийг хамардгаараа

онцлог агаад Чи ч намын лидер, Би ч намын лидер хоёулаа сонгогдох зарчим буюу “хүчтэнгүүд”-ийн хийх үйл юм. “Жижиг” намуудын хувьд “манайх хүнээ дэвшүүлнэ тэгэхдээ таныг, танай намын нэр дэвшигчийг дэмжиж ажиллана, өрсөлдөгчийн чинь саналыг хуваана, харин та ялахаараа манийгаа битгий мартаарай” гэсэн болзолтойгоор энэ тоглолтонд оролцоно.

“Том” “жижиг” намууд эвсэл үүсгэн оролцоходоо тойргоо мөн тохирох бөгөөд энд “АХ” эвсэл, “Эх

### АСУУЛТ 2. СОНГУУЛЬД “НҮДЭЭ ОЛСОН” ЗӨВ ХҮНЭЭ ДЭВШҮҮЛДЭГ ҮҮ? МӨН СОНГОГЧИД ҮҮНД ОРОЛЦОЖ ЧАДДАГ УУ?

Бие даагчдыг төдийлөн таалдаггүй Монголчуудын хувьд аль намаас хэнийг дэвшүүлж байна, түүнийг нь сонгоход хүрдэг бөгөөд нэр дэвшүүлэх үйл явц гагцхүү улс төрийн намын үйл хэрэг болж, иргэдийн оролцоо үндсэндээ тэг хувилбарт шилжжээ.

Уг нь сонгуулийн тойрогт аль чадалтай, олонд хүндтэй нэгнээ нэр дэвшүүлдэг болох гэсэн эрмэлзэл намуудад байсан, түүнээ хэрэгжүүлэх гэж үзсэн ч “их санасан газраа есөн шөнө хоосон хононо” гэдгийн адил амжилтанд хүрээгүй. Тухайлбал, МАХН (хуучнаар)-ын судалгааны Прогноз ( хуучнаар) төвөөс УИХ-ын сонгуулийн өмнө тойрог бүрд сонгогчдын дунд санал асуулга явуулж нэр дэвшигчээ тодруулах гэсэн авч санал асуулгын дүнг засах, чинийх арван хувь, минийх аравхан хувь гэх мэтээр самарснаас бөөн будилаан гарч “бид одоохондоо ийм түвшинд хүрээгүй байна, дарга нар шийдэх нь зүйтэй амой” гээд орхисон байна. Мөн АН ч ийм оролдлого хийж ерөнхийлөгчийн сонгуульд зөв хүнийг дэвшүүлэх сунгааг Америкийн праймериз (presidential primaries) жишгээр хийсэн ч мөн бүтэлгүйтсэн. Одоо ч гэсэн [МАН](#) бол 369 гишүүнтэй бага хурлаасаа, [АН](#) анхан шатны намын байгууллагаас шаталсан зарчмаар УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлж байгаа боловч бодит сонголт намын эрх баригчдын хүрээнд шийдэгдсэн хэвээр байна.

Тойрог хуваах дараагийн үйл явц нам дотроо үргэлжлэн өрнөнө. Эхлээд намаасаа нэр дэвших эрхийн төлөө тэмцэлдэх бөгөөд хэн намын удирдлага, нөлөө бүхий фракцид ойр байна,

орон ардчилал эвсэл”, “МАХН-МҮАН-ын шударга ёс эвсэл” зэрэг эвслийн жишээг дурдаж болно. Харин “том” намуудад “тоогдоогүй” жижиг намууд “Иргэний эвсэл”, “Эх орончдын эвсэл”, “Гурав дахь хүчин эвсэл”, “Тусгаар тогтнол-эв нэгдэл эвсэл” зэрэг эвслүүдэд нэгдэж УИХ-ын сонгуульд оролцож байсан боловч нэг их амжилтанд хүрээгүй, харин “ах” намуудаа шууд болон шууд бусаар дэмжсэн байлаа.

хэн мөнгөтэй түүнээ зөв хүнд, зөв цагт нь өгч чадсан тэр нөхөр нэр дэвших эрхээ олж авах бөгөөд улмаар аль тойргоос вэ? гэдэг дараагийн тэмцэлд ханцуй шамлан орно. Мэдээж намуудын удирдлагын түвшинд хийсэн тойргийн хуваарилалтын дагуу “үхлийн” гэсэн тодотголтой тойрогт хэн ч очихыг хүсэхгүй боловч аанай л “хоншоор нь дутсан хэн нэгэн товариш золиос болон тийш шидэгдэж нам ялбал албан тушаал бат гэсэн “амлалт” өвөрлөн одно.

○.....○  
*Тойрог хуваахад “тойргоо усалсан эсэх” чухал бөгөөд энэ нь улс орны хэмжээнд сэтгэж, бүтээж ажиллах үүрэгтэй УИХ-ын гишүүдийг “жалга довын депутат” болгож, сонгогч олны үнэлгээг ч жишгээрүүлж төрийн хөрөнгөөр барьсан сагсан бөмбөгийн талбай зэргээр гишүүнээ үнэлдэг явдлыг архагшуулан гааруулдаг ноцтой үр дагавар дагуулна. Үүнээс үүдээд бараг л аятайхан “жорлон” барьчих юм бол их хурлын гишүүд гүйж очин нээлт хийн тууз хайчилж зогсдог уламжлал бий болсон нь бас нэг үнэн.*

○.....○  
Тойргоо ийн усалж чадсан нь тойрогтоо үлдэх, чадаагүй нь дараагийн “шанстай” тойргийг сонгох гэж дайны хажуугаар дажин өрнүүлнэ. Уул шугамандаа нэр дэвшихийн төлөө ил тод, шударга өрсөлдөөн өрнөх нь ардчилсан либераль нийгмийн ердийн хэм хэмжээ. Харамсалтай нь Монголд нам хоорондын хуйвалдаан, нам доторх хор найруулалт, “өөрийн хүнийг” дэвшүүлэх бүлэг фракц хоорондын далд нуугдмал, эрх мэдэл, мөнгөний өрсөлдөөн болсон нь Монголчуудын сонгох, сонгогдох эрхийн бас нэгэн хулгай болжээ.

### АСУУЛТ 3. НЭР ДЭВШИГЧИЙН ТУХАЙ ҮНЭН ЗӨВ МЭДЭЭЛЭЛ АВЧ, ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОЛТ ХИЙЖ ЧАДДАГ УУ?

Нэр дэвшигч, түүний мөрийн хөтөлбөрийн тухай хүртээмжтэй, үнэн зөв мэдээлэл авах нь Сонгох эрхийн хэрэгжилтийн нэг чухал нөхцөл. Нэр дэвшигч ч шударга, ёс зүйтэй байж, сонгогчдын ухамсартай, эрүүл сонголт хийх нөхцлийг хангах ёстой. Иймээс ч сонгуулийн тухай хууль тогтоомжид “хуурч мэхлэх”, “эд мөнгөөр татах” болон “сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах”-г хориглосон нь бий.

Бодит амьдрал дээр байдал огт өөр. Нэр дэвшигчийн сурталчилгааны үйл ажиллагаа 1.Хууль журмын дагуух ил хувилбар болон 2. “Ирлэсэн тонгорог шиг байж, элдвийг хийнэ” гэх нууц хувилбараар явна. Анхдугаар хувилбар бол мөрийн хөтөлбөр, захидал, нэрийн хуудас, сонин, сэтгүүл зэрэг хэвлэмэл материал тарааж, уулзалт зохиож, зураг хөргөө зөвшөөрсөн газар мандуулж, хэвлэл мэдээлэл, цахимаар сурталчлах зэрэг хуульд заасан зүйлсийг хийхийг хэлнэ. Энэ үеэр хийдэг зүйлс бүх нэр дэвшигчдийн хувьд ойролцоо ч “түрийвч болон бэлчээрийн хэмжээ”-ээс сурталчилгааны цар хүрээ, “нүнжиг” хамаарна. Энэ бол мөсөн уулын зөвхөн харагдах хэсэг нь.

Нөгөө “Ирлэсэн хутга мэт” гол нууц хувилбар нэр дэвшигчийн дийлэнх цаг хугацаа, хөрөнгө мөнгө, хүн хүчийг сорно. Тус хувилбарын эхний шатанд нэр дэвшигч тухайн тойрог дахь өөрийн намын гишүүн, идэвхтнүүдээ тойглох ажлыг хийнэ. Ингэхдээ ялахын өмнө буюу цалин нэрээр өгөх мөнгө, бусад “халамжийн зүйлс” болон ялсны дараа “ажил албан тушаал амлах”, “гадаадад амралт зугаалгаар явуулах”, эрх мэдлийн бусад буян хишгээ хуваалцах зэрэг амлалт өгч хэрэгжүүлэхээс эхэлнэ.

Тэдний ажлын зохион байгуулалт нь дор дороо хариуцан санал өгүүлэх “тавт” “аравт”-ын системээр явах, мөн хамгийн нэр нөлөөтэй, идэвхтэй хэсэг нь нэр дэвшигчийг тухайн тойргийн “найдартай” хүмүүс, төрийн бус байгууллагуудтай холбох ажлыг хариуцна. Энэ хувилбарын гол тулгуур багана, зарчим нь бүх нэр дэвшигчдийн хувьд нийтлэг байдлаар явдаг. Үүнийг тоймлон харъя:

- ♦ **ТАВТ, АРАВТЫН СИСТЕМ:** Нэр дэвшигчийг дэмжигч бүр доороо таваас арван хүн хариуцаж санал өгүүлэх бөгөөд тэднийг тойглох, бусдад алдахгүй байх бүх ажлыг нэр дэвшигчийн штабын өмнө хариуцахыг хэлнэ. Энэ схем нь сүлжээний бизнестэй ижил загвараар

явах бөгөөд аалзны тор мэт тойргийн бүх сонгогчийг хамрах зорилго агуулна.

- ♦ **“ЗОРИЛТОТ БҮЛГҮҮДТЭЙ” АЖИЛЛАХ:** Тухайн тойрогт байгаа нэг нутаг усныхан, ах дүү хамаатан садан, нийгмийн эмзэг бүлгийнхэн, залуучуудын байгууллага, ахмадын холбоо, СӨХ, нутгийн зөвлөл зэрэг төрийн бус байгууллагууд тэр бүү хэл архаг архичдын бүлгийг анхааралдаа авч, тэдэнд таарч тохирсон амлалт, гар цайруулах мөнгө төгрөгөөр тордох ажлыг зохицуулна. Энэ үеэр сийрэгхэн зарим нэг нь өөрийн бүлгийн гишүүдийн иргэний үнэмлэхийг цуглуулаад барьчихсан, ийм мөнгө, тийм юм бүтээж өгөөл саналаа танд өгнө гэхчхэн ил тод явах нь бий.
- ♦ **БҮХ ХҮНТЭЙ ТУЛЖ АЖИЛЛАХ:** Нийгэм цахимжсан нь уг схемийг улам ач холбогдолтой болгож байна. Нэр дэвшигч бүр өөрийн тойргийн сонгуулийн насны бүх хүний дэлгэрэнгүй бүртгэлийг улсын бүртгэлийн албадаас олж авна. Уг нь хуулиар хориотой боловч “болно, болохгүй юм байхгүй” зарчимтай нийгэмд бол хамаагүй. Дээр нь СӨХ, Ахмад, залуучуудын байгууллага гэх мэт ТББ өөрсдийн мэдлийн бүртгэлийг мөн нэр дэвшигчид “гардуулна”, гэхдээ төлбөртэй. Сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн байгууллагуудын өрийн данс хүртэл “зүйлгээнд” орчихсон цохиж явдаг болж. Мэдээж, таны талаарх бүх мэдээлэл байгаа хойно гар утас руу чинь залгаад “эмзэг асуудлыг” тань шийдэж өгөх амлалт өгч тодорхой нэр дэвшигчийн төлөө саналаа өгөхийг уриална. Үүний тулд бүхэл бүтэн утасны компани шиг бүтэц ажиллана. Татгалзаж боломгүй санал авсан хүн яах билээ дээ, саналаа өгч л таарна.
- ♦ **САНАЛ ХУДАЛДАГДАХААС СЭРГИЙЛЖ ХУДАЛДАН АВАХУЙ:** Нэр дэвшигч бүр “хэлэмгий хүн сурамгай” гэдгийн адил өрсөлдөгчөө хууль бус юм хийж байгаа гэдэгт бүрэн итгэлтэй байдаг. Энэ итгэлийг нь түүнийг тойрон хүрээлж байгаа штаб, намын идэвхтэн, сонгуульт ажилтан, “сайныг хүсэгч” бүр бэхжүүлнэ. Тэд янз янзын кейс жишээ татах бөгөөд өөрийн дэмжлэгээ санал болгож буй гадны нөхдүүд ч хэрэв та зөвшөөрөхгүй бол таны өрсөлдөгч дээр очно доо, тэр намайг бүр гуйгаад байгаа гэх зэргээр сүрдүүлэн “айлгана”. Хаданд хавчуулагдсан халиуны зулзага мэт болсон нэр дэвшигч маань саналаа өрсөлдөгчдөө алдахгүйн тулд урьдчилан сэргийлэх зарчмаар алгаа тэнийлгэнэ. “Авсан хүн нэг тамтай, алдсан хүн арван тамтай” гэдгийн үлгэрээр нэр дэвшигч цуглуулсан хэдээ алдчихгүйн тулд сонгууль дуусан дуустал аргадан тойглох болно. Энэ бүхэн мөнгө, асар их мөнгө шаардана. Үүнийг нэр дэвшигч хувийн данснаасаа түүнчлэн ивээн тэтгэгч нараасаа гаргуулна. Энэ нь

## САЙН ЗАСАГЛАЛ

*түүнийг бас л хэн нэгэнд өртэй болгож, аяганы хариу өдөртөө агтны хариу жилдээ гэгчээр хэзээ нэгэн цагт албан тушаал, хууль бус давуу байдал гэх мэт зүйлээр өрөө төлөхөд хүргэж, барьцаална.*

2016 оны УИХ-ын сонгуульд нийт 12 нам, 3 эвсэл, 498 нэр дэвшигч оролцсон аж. ҮАГ-аас гаргасан аудитын дүнд дурдсанаар сонгуульд оролцсон 11 нам, 2 эвсэл нийт 8,363.9 сая төгрөг төвлөрүүлснээс 8,349.3 саяыг нь зарцуулжээ. Харин 498 нэр дэвшигчээс 386 нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасны дагуу холбогдох төрийн байгууллагуудад ирүүлсэн нь

### АСУУЛТ 4. ЭНЭ БҮХ ХУЛГАЙГ НЭР ДЭВШИГЧ ЗОХИОН БАЙГУУЛДАГ УУ?

Тийм бас үгүй. Анх энэ бүхнийг улс төрчид, намууд оруулж ирсэн бөгөөд “ариун газар хоосон байдаггүй”-н үлгэрээр бүр бие даасан тогтолцоо систем болон хувирсан гэдэг утгаараа ТИЙМ. Нөгөө талаас эрэлт байгаа газар нийлүүлэлт бий болох зах зээлийн зарчмаар сонгуулийг мөнгө олох хэрэгсэл болгон хувиргадаг нийгмийн бүхэл бүтэн бүлэг давхраа бий болсон бөгөөд тэд нэр дэвшигчдэд “татгалзах аргагүй санал дэвшүүлж” мөнгө сааж, ашиг олдог болсон нь

### АСУУЛТ 5. ХҮН БҮР СОНГОХ ЭРХЭЭ ХУДАЛДАГ ГЭЖ ҮҮ?

Мэдээж үгүй. Өөрийн итгэл үнэмшил, үзэл бодол, таалах эс таалах зан үйлдээ захирагдан саналаа өгдөг хүмүүс дийлэнх байгаа ч эдний тоо улам цөөрсөөр байна. Тэд саналаа худалдахгүй ч санал хураах байранд ирэхээс сайн дураар татгалзах болсноор “санал худалдагч, худалдан авагч” олонх болох аюул бодитой боллоо. Ерөнхийлөгчийн 1993 оны сонгуульд 92.7 хувьтай оролцож байсан сонгогчдын тоо буурсаар 1997 онд 85.6 хувь, 2001 онд 83 хувь болж 2017 онд 60.6 хувь болж унав. УИХ-ын сонгуулийн ирц ч мөн адил. Орон нутгийн хурлын сонгуулийн ирц

### АСУУЛТ 6. СОНГОХ СОНГОГДОХ ЭРХИЙН ХУЛГАЙГААС ЗАЙЛСХИЙХ АРГА ЗАМ БАЙНА УУ?

Үндсэн хуульд заасан язгуур эрхээ шударгаар, сэтгэл ханамжтайгаар эдлэх боломжийг бүрдүүлэх олон арга зам байдаг талаар судлаачид, улс төрчид, мэргэжилтнүүд хэлдэг, ярьдаг.

*Үүнийг бичигчийн хувьд бол сонгуулийн саналын хуудсанд нэр дэвшигчдээс гадна БҮГДИЙН ЭСРЭГ гэсэн сонголтыг оруулж өгөх хэрэгтэй санагдана.*

Зарим хүмүүс хэрэв ингэвэл сонгууль нурна, дахин сонгууль зохион байгуулах гэж төсвийн асар их хөрөнгө мөнгийг зарах шаардлага гарна гэж “санаа

нийтдээ 26,010,9 сая төгрөг болжээ. [Эндээс харахад](#) нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын нийлбэр дүн 34 тэрбум 360.2 сая төгрөг болж байна.

Дээр дурдсан бүхэн мөрийн хөтөлбөрөө уралдуулж, мэдлэг ур чадвар, туршлага, ёс зүйгээ сойж сонгогчийн санал авах зорилготой сонгуулийн сурталчилгааг оронгоор нь эргүүлж, сонгох эрх гээчийг ул болгон, мөнгө төгрөг, эрх мэдлийг зул болгон залснаар сонгох, сонгогдох эрхийн хулгайн бас нэг хэлбэр болж хувирна.

үнэн. Энэ утгаараа нэр дэвшигчид бас “хохиорогч” болох нь олон.

*Сонгуулийн үеэр ашиг олдог энэ бүлэглэлүүд улам зохион байгуулалттай, хууран мэхлэх, залилах, айлган сүрдүүлэх хэлбэрт шилжсэн бөгөөд хууль хяналтын байгууллагаас энэ мэтийн “бизнес эрхлэгчидтэй” ямар ч тооцоо боддоггүй учир бүр даамжирсаар, сонгох сонгогдох эрхийн хулгай гаарчихсан.*

арай ядаж 50+1 болж, зарим газар ирц хүрэхгүй дахиж байна.

*Үүний шалтгаан нь намуудын дэвшиүүлж байгаа нэр дэвшигч сонгогчийн сонголтонд нийцэхээ больж, “өвсөнд ороовч үхэр үл идэх” болж хувирсантай иүүд холбоотой. Нэгэнт таалахгүй хүнээ хүчээр сонгохгүйн тулд саналаа өгөхөөс татгалзах болж улмаар саналаа өгсөн ч тэмдэглэл хийхгүй цагаан хуудас унцуулж байна. Энэ байдал даамжрах аваас бид удахгүй сонгуулиа явуулж чадахаа болих магадлалтай.*

зовдог”. Үнэхээр сонгуульд бид төсвийн багагүй мөнгийг зардаг ч чадамжгүй, шударга бус, сонирхлын зөрчилд идэгдсэн хууль тогтоох байгууллагын өр төлөөсийг хэмжих аргагүй бөгөөд үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолоороо дэнчин тавихад хүрснээс дахиад хэдэн тэрбумыг зарахад яахав. Нэр дэвшигчдийг нь сонгогчид хүлээж авахгүй байх аваас намууд ч гэсэн “нүдээ олсон” хүнийг дэвшүүлэхийг хичээнэ, сонгогч ч хариуцлагатай сонголт хийж, хулгайг даран Сонгох сонгогдох эрхээ жинхэнэ утгаар эдлэх буй заа.





**Б.ЦЭЦЭГСАЙХАН**

Хавдрын үндэсний зөвлөл ТББ-ын гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор

**НИЙТЛЭЛ**

## ТАМХИ БОЛ ХЭРЭГЛЭГЧДИЙНХЭЭ ТАЛААС ИЛҮҮГ НЬ




# ҮХҮҮЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН

**Х**эрэглэгчдийнхээ тал хувийн аминд хүрдэг, хорт хавдрын гол шалтгааны нэг бол тамхи. Дэлхий дээр жил бүр 7 сая хүн тамхины улмаас амь насаа алдаж байна. Энэ нь ДОХ, сүрьеэ, халуун хумхаа зэрэг өвчнүүдийн улмаас нийт нас барж байгаа хүмүүсээс олон хүн гэсэн үг. Нас баралтын 80 хувь нь хөгжиж буй ядуу буурай орнуудад тохиолдож байгаа ба энэ орнуудад дэлхийн хэмжээнд тамхи татдаг хүмүүсийн 80 хувь нь амьдарч байна.

Ийм учраас дэлхий даяар жил бүрийн 5-р сарын 31-ний өдрийг Дэлхийн тамхигүй өдөр болгон, тамхины аюул, хор нөлөө, дам тамхидалтын хор уршгийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулдаг. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Тамхины хяналтын суурь конвенц 2005 онд батлагдсанаас хойш 179 орон конвенцид нэгдэн дэлхий дахинд тамхины хяналтын үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч

байна. Өндөр хөгжилтэй орнуудад тамхины хяналт сайжирч хэрэглээ буурсан бол, эсрэгээрээ тамхины хяналт сул байгаа бага болон дунд орлоготой орнууд руу тамхины асар том зах зээл шилжсэн.

Дэлхий дахинд тамхины хэрэглээг хязгаарлах хамгийн үр дүнтэй арга бол тамхины татварыг нэмэгдүүлэн, хүртээмжийг хязгаарлах бодлого гэж тооцдог. Тамхины татварыг нэмэгдүүлж, үнийг өсгөх нь хүмүүсийг тамхинаас гаргаж, ялангуяа залуучуудыг тамхи татаж эхлэхээс хамгаалдаг. Түүнчлэн, эрүүл мэндийн салбарын ачааллыг бууруулахаас гадна эдийн засагт эерэг нөлөөтэй. Тамхины үнийг 10 хувь нэмэгдүүлэхэд хэрэглээ 2-8 хувь буурдаг олон орны жишээ байна. 2025 он гэхэд тамхины хэрэглээг 30 хувь бууруулах Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын зорилтод хүрэхийн тулд тамхины татварыг 7 дахин нэмэгдүүлэх шаардлагатай гэж үздэг.



Монгол улсын хувьд нас баралтын зонхилон тохиолдох шалтгаан нь зүрх судасны өвчлөл болон хавдар. Эдгээрийн 20 хувь нь тамхитай холбоотой буюу өөрөөр хэлбэл урьдчилан сэргийлж болохуйц нас баралт байна гэсэн үг. Сүүлийн 10 жилд тамхинаас үүдэлтэй зүрх судасны эмгэгээр нас барах явдал 2 дахин нэмэгдэж, нас барж байгаа 3 хүн тутмын нэг нь зүрх судасны эмгэг, 5 хүн тутмын нэг нь хорт хавдрын улмаас нас барж байна гэсэн тоон үзүүлэлт гарсан.

**Манай улс тамхины хэрэглээ хамгийн өндөр орнуудын тоонд ордог бөгөөд насанд хүрсэн 2 эрэгтэй хүн тутмын нэг нь тамхи татдаг. Биг 2017 онд 2.9 тэрбум ширхэг тамхи импортлосон нь 2003 оноос 4 дахин өссөн үзүүлэлт байна. 2017 онд 141 тэрбум төгрөгийг зөвхөн тамхи импортлоход зарцуулжээ.**

## ТА ӨӨРӨӨ ТАМХИ ТАТДАГГҮЙ БОЛ ТАНД ЭРСДЭЛ БАЙХГҮЙ ГЭСЭН ҮГ БИШ


Учир нь дам тамхидалтад өртсөн хүн тамхи татагчийн адил өвчин тусах эрсдэл өндөртэй. Хамгийн аймшигтай тоо бол Монгол хүүхдүүдийн 42,4 хувь нь гэртээ дам тамхидалтад өртдөг байна.

Монгол Улс Дэлхийн Тамхины хяналтын суурь конвенцид нэгдэн орсон улсын хувьд тамхины татварыг үе шаттай нэмэгдүүлэх үүргийг олон улсын өмнө хүлээсэн байдаг. Үүний дагуу 2012 оны 9-р сард тамхины онцгой албан татварын хэмжээг дотоодын тамхины хувьд хайрцаг тутамд 0.12-оос 0.48 ам. доллар, харин импортын тамхины хувьд 0.24-0.48 ам.доллар хүртэл нэмэгдүүлсэн. Тамхины татварыг нэмэгдүүлсний үр дүнд хэрэглээ 17.5 хувиар буурч, улсын төсөв 2012-2013 онд 57.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байдаг.

Харин 2015 оны 1-р сарын 1-ээс эхлэн тамхины татварын хэмжээг төгрөгөөр буюу 1 хайрцаг тутам 696 төгрөгөөр тооцох болсноос үүдэн тамхины татварын орлого 2014 онд 134.8 тэрбум байснаас 2015 онд 104.3 тэрбум төгрөг болж буурсан. Хэдий тамхины импортын татвар, тамхины онцгой албан татвар 2018-2019 онуудад бага зэрэг нэмэгдсэн ч тамхины үнэ хямдхан хэвээрээ л байна.

**Иймд биг дэлхий нийтийн өмнө тавьсан зорилтгоо хүрэхийн тулд 2025 он гэхэд хайрцаг тамхины үнийг 9945 төгрөг хүргэх буюу тамхины татварыг 9 дахин нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн тооцоолол байдаг.**

STRATEGY



Улс орнууд тамхины хяналтын хуулийг чангатгах, тамхины татварыг нэмэгдүүлэх, электрон тамхийг янжуур тамхитай адил авч үздэг болох зэрэг олон цогц арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байна. Тамхины хяналтаар дэлхийд тэргүүлж буй Австрали улс гэхэд тамхины хяналтын талаар сүүлийн 30 жилд авч хэрэгжүүлсэн цогц арга хэмжээний (тамхины татварыг нэмэгдүүлэх, 2020 он гэхэд нэг хайрцаг тамхины үнийг 40 долларт хүргэх, тамхигүй орчин бүрдүүлэх, стандарт тамхины хайрцагтай

болох, тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх гэх мэт) үр дүнд тамхины хэрэглээг 39 хувиас 13 хувь хүртэл бууруулан тэргүүлж байна.

Хорт хавдар, зүрх судасны өвчлөлийн гол шалтгаан, хэрэглэсэн хэрэглэгчдийнхээ тал хувийнх нь амь насанд хүрдэг тамхины талаар дорвитойхон арга хэмжээ авах, үнийг нэмэгдүүлэх замаар үр хүүхдийнхээ эрүүл мэндийг хамгаалахад анхаарах цаг болжээ.

2019 оны 5-р сар

# The Defacto Gazette

INFORMING | INSPIRING | EMPOWERING

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН, УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

**ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА**

**УЛИРЛЫН ЗАХИАЛГА: 30.000₮**



ТА МОНГОЛ, АНГЛИ, ЯПОН ХЭЛЭЭР ЗАХИАЛАХ БОЛОМЖТОЙ.

МОНГОЛ ШУУДАН | 7007-8916



## ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг ДеФакто тоймын эмхэтгэл:  
2019.05.26-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

## ХӨГЖЛИЙН БАНК БОЛОН ЭРДЭНЭТИЙН ШАЛГАЛТЫН ДҮН

### Үйл явдлын товч:

Засгийн газар өнгөрсөн долоо хоногт хэд хэдэн төрийн өмчит аж ахуйн нэгжид хийсэн хяналт, шалгалтын талаар олон нийтэд мэдээлэл өгсөн. Тухайлбал, Хөгжлийн банкинд хийсэн шалгалтын дүнг ажлын хэсгийн ахлагч ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ танилцуулж шалгалтаар илэрсэн зөрчлүүдийн талаарх материалуудыг холбогдох хууль хяналтын байгууллага, АТГ-т шилжүүлж байгаагаа мэдэгдсэн.

Харин Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Эрдэнэт үйлдвэрт хийсэн хяналт, шалгалтын дүнг танилцуулж ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй гэх материалуудыг холбогдох хуулийн байгууллагуудад мөн адил хүргүүлж байгааг мэдэгдсэн. Мөн ажлын хэсгийн ахлагч Монголросцветмет компанид хийсэн шалгалтаар санхүүгийн хүндрэлтэй байгааг тогтоосон талаар дурдсан.

### Дүгнэлт тайлбар:

Их хурлын даргыг өөрчилсөн “чимээгүй” өөрчлөлт их том явлаа шүү дээ. Үүнийхээ үр дүнг гаргах зам эхэлж байгаа нь энэ гэж харж байна. Дээрх хоёр том хэргийн талаар өнөөг хүртэл ярьж байсан ч АТГ-руу шилжүүлж чадахгүй байсан. АТГ-ын даргыг сольсон, шинэ дарга нь

эдгээр хэргүүдийг шийднэ гэж амалсан. Бидний гол анхаарах зүйл бол дээрх хэргүүдийг хийсэн хүмүүст яг хариуцлага хүлээлгэх үү? Үгүй юу гэдэг. Хариуцлага хүлээлгэж байж л өнөөг хүртэл ярьж ирснээс ялгарна, чадахгүй бол урьдын адил хоосон шуугиан болж үлдэнэ. Ямар ч ялгаагүй. Өмнө нь хэн нэгнийг бариад л, хориод л, айлгаад л чимээгүй болж мартагддаг байсан шүү дээ.

Хариуцлага хүлээлгэнэ гэсэн хүлээлт нийгэмд байгаа ч хариуцлагыг 2 янзаар ойлгож байна. Иргэд бол алдсан мөнгөө буцаагаад авна гэж ойлгож байгаа, харин төр засаг хуулийн дүгнэлт гэх мэтийг тараагаад, баривчилж айлгаад болдог гэж ойлгоод байгаа юм. Гол зүйл бол бид алдсан хөрөнгө мөнгөө олж авах. Тэр мөнгө зээлийн мөнгө байсан шүү дээ, үүнийг одоо иргэд татвараараа төлж байгаа. Таны 10 зүсэм талхны 2-ыг нь төр авчихаад, түүгээрээ эдгээр хариуцлагагүй хүмүүсийн зээлсэн зээлийг төлөөд байгаа юм.

Хөгжлийн банкны зээл бол МУ-ыг хөгжүүлэх урт хугацааны том төсөлд хариуцлагатайгаар, зээл зарчмаар хөрөнгө оруулах ёстой. Түүнээс арилжааны банкуудын өгчих зээлийг өгөх ёсгүй. Гэвч үүний хариуцлагын тогтолцоог нь хянаж чадаагүй учраас ийм байдалд хүрчихсэн.

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХАРИУ ЦОХИЛТ

### Үйл явдлын товч:

Ерөнхийлөгч Х.Баттулга өнгөрсөн Пүрэв гарагийн УИХ-ын нэгдсэн чуулганд оролцож УИХ-ыг хугацаанаасаа өмнө тарах саналыг 2 дахь удаагаа гаргалаа. Үүний өмнө тэрээр өнгөрсөн оны 10-р сард УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон учир өөрөө тарахыг санал болгож байсан. УИХ-ын үйл ажиллагаа тухайн үеэс сайжирсангүй гэж үзэн дахин санал гаргасан гэв.

Мөн УИХ-ын баталсан татварын багц хуульд өнгөрсөн 7 хоногт хориг тавиад байсан. Гэтэл Сангийн сайд Ерөнхийлөгч хүчингүй болчихсон хуульд хориг тавьсан. Тийм учраас Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах



Khurelbaatar Chimed  
@KhurelbaatarCh

Follow

Татварын багц хуулинд бүхэлд нь хориг тавихдаа 2006 онд хүчингүй болсон, байхгүй хуулинд хориг тавьчихжээ. Хуулиа уншдаггүй юм гэхэд ядахдаа хуулийн нэрийг нь уншиж баймаар юм.

10:45 AM - 16 May 2019

362 Retweets 504 Likes

56 362 504

боломжгүй гэж мэдэгдсэн. Улмаар УИХ-ын харьяалах хороодууд уг хоригийг хүлээн авах боломжгүй гэж үзээд байна.

### Дүгнэлт тайлбар:

Манайд батлагдаж байгаа хуулиуд судалгаагүй, хувь хүмүүсийн үзэмжид тулгуурласан, нэг сонгуулийн хугацаагаар харсан богино настай байдаг. НӨАТ, боловсролын хууль, уул уурхай ашигт малтмалын хуулийг 16 жилд 300 удаа өөрчилсөн нь ажлаа хийж мэдэхгүй байгаагийн тод жишээ. Хуулиа гаргаж чадахгүй, гаргасан хуулиа хэрэгжүүлж чадахгүй, зөрчсөн хүнээ шийтгэж чадахгүй төртэй улс. Ерөнхийлөгч, улсын их хурал 2 институтынхаа хувьд бэхжиж чадаагүй байна гэсэн үг.

Мөн өнгөрсөн 7 хоногт Засгийн газрыг огцруулах машинтай жагсаал болсон. Махны үнэ, шатахууны үнийг барьж чадсангүй гэж. Энэ бол Засгийн газар нь мах, шатахууны үнийг өөрөө тогтоодог гээд итгэчихсэн, ард түмэндээ итгүүлчихсэн байгаагийн илрэл. Одоо хүртэл Засгийн газар гэдэг институт үнэ тогтоодог газар биш гэдгээ ойлгоогүй байгаа байхгүй юу.

Гэхдээ ардчилсан нийгэмд жагсаж байж л өөрсдийгөө илэрхийлдэг.

## ЕВРАЗИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ФОРУМ 2019

### Үйл явдлын товч:

Казахстан Улсад жил бүр дэлхийн 60 орны 600 гаруй төлөөлөгч оролцдог “Евразийн хэвлэл мэдээллийн форум” болдог. Энэ жилийн форум 5-р сарын 22-24-ний өдрүүдэд Алмата хотод боллоо.

### Дүгнэлт тайлбар:

Казахстан улс Евразийн энэ орон зайд өөрсдийгөө төв болгохоор ажиллаад их олон жил болж байгаа. Нэг удирдагчтай 30 жил байж, энэ удирдагч нь өөрийн шилжилтийн үйл ажиллагааг явуулаад эхэлсэн. Ази Европыг холбосон олон бизнесийн санхүүгийн төв байгуулчихсан байна. Астанагийн эдийн засгийн форум гээд сая 12 дахь жилдээ зохион байгуулчихлаа. Алматад энэ хэвлэл мэдээллийн форум 16 дахь жилдээ зохион байгуулагдаж байна. Энэ бүхэн бол Казахстан гэдэг улс энэ орон зайдаа хамгийн том нь, төв нь гэсэн ойлголтоор явж байгаагийн нэг илрэл.

Форумын үеэр барууны нэг сэтгүүлч “яагаад бид энэ форумыг хүний эрхийг зөрчдөг, сэтгүүлчдийг



өөр үзэл бодол илэрхийлэхийг нь хорьдог, оройн цагаар интернетийн хурдыг удаашруулдаг ийм оронд хийж байгаа юм бэ” гэж асуухад “харин тийм учраас л энд хийж байгаа шүү дээ” гэж хэлж байна лээ.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв  
Тоймын бүрэн эхийг [jargaldefacto.com](http://jargaldefacto.com) вебсайтаас үзэх боломжтой.

 **WORLDWINE**  
Prosecco Bar



1 давхар, БУДА виста  
Утас: 7777-4747

GOOGLE STORE



APP STORE

